УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2022/166/НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2022 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Т.Намжил<br>Утас: 70453721, Цахим хаяг: NamjilT@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ..... 2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 2
3. Аудитын тайлан ..... 3
3.1 Ерөнхий зүйл ..... 14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 14
3.4 Материаллаг байдал ..... 15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 17
3.8 Аудитын гол асуудал ..... 17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 18
4. Аудитын илрүүлэлт ..... 18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 19

ХОВД СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
А.НАЗГҮЛ ТАНАА


**УВС АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn


2022. 02. 25 № УВА - 2022/166/НА - СТА - ТИЗ

танай________________-ны №____________________-т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

0200200769

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **19,932,493.20** | **84,209,771.87** |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | | |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | | |
| | Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | | 2,641,804.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | | 2,641,804.00 |
| 3121 | Төгрөг | | 2,641,804.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | | 1,421,804.00 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | | 1220,000.00 |
| 33 | Авлага | 13,360,427.00 | 43,334,446.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | | 42,975,200.00 |
| 335 | Бусад авлага | 1,336,427.00 | 359,246.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,336,427.00 | 359,246.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **18,596,066.20** | **38,233,521.87** |
| **35100** | **Түүхий эд материал** | **7,602,046.00** | **24,044,187.67** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | | |
| 35130 | Эм боох материал | 7,602,046.00 | 24,044,187.67 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | | |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | | |
| **35400** | **Хангамжийн материал** | **10,994,020.20** | **14,189,334.20** |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 11,250.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 10,698,960.00 | 13,421,540.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 220,000.00 | |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 10.20 | 698,510.20 |
| 35450 | Барилгын засварын материал | | |
| 35460 | Хүнсний материал | 75,050.00 | 58,034.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | | |
| 35500 | Биологийн хөрөнгө | | |
| 35600 | Мал амьтад | | |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **693,022,513.42** | **739,401,214.25** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **693,022,513.42** | **739,401,214.25** |
| 39100 | Газар | 10,620,000.00 | 10,620,000.00 |
| **39200** | **Биет хөрөнгө** | **682,402,513.42** | **728,781,214.25** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 637,347,667.48 | 637,347,667.48 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -31,455,645.82 | -46,154,591.14 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 36,170,000.00 | 85,570,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -12,649,999.98 | -19,364,444.41 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 131,608,187.01 | 165,584,636.57 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -92,241,321.19 | -105,920,640.13 |

| | | | |
|---|---|---|---|
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 24,483,045.00 | 24,483,045.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -10,991,419.08 | -12,896,459.12 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | | |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | | |
| 39212 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | | |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | | |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | | |
| 39217 | Ном | 132,000.00 | 132,000.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | | |
| 39301 | Программ хангамж | 440,000.00 | 440,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -440,000.00 | -440,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **712,955,006.62** | **823,610,986.12** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **13,117,929.00** | **30,954,016.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **13,117,929.00** | **30,954,016.00** |
| **413** | **Өглөг** | **13,117,929.00** | **30,954,016.00** |
| 4131 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 1,097,899.00 | |
| 4136 | Бусад өглөг | 12,020,030.00 | 30,954,016.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 12,020,030.00 | 3,586,516.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | | 27,367,500.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **699,837,077.62** | **792,656,970.12** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **699,837,077.62** | **792,656,970.12** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 186,728,771.31 | 186,728,771.31 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **323,789,161.31** | **416,609,053.81** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 323,789,161.31 | 323,789,161.31 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 92,819,892.50 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 189,319,145.00 | 189,319,145.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **712,955,006.62** | **823,610,986.12** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **440,611,446.00** | **711,806,985.23** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **22,182,996.00** | **100,025,205.23** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **22,182,996.00** | **100,025,205.23** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **22,182,996.00** | **100,025,205.23** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 22,182,996.00 | 100,025,205.23 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал | | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **76,905,350.00** | **211,529,280.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 341,523,100.00 | 400,252,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **18,847,900.00** | **105,873,300.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж | | 2,000,000.00 |
| | | | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 18,847,900.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 103,873,300.00 |
| | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 30,075,300.00 | 37,507,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 30,075,300.00 | 37,507,000.00 |
| | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс | 27,982,150.00 | 68,148,980.00 |
| | Эрүүл мэндийн даатгалын сангаас | 27,982,150.00 | 68,148,980.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **469,167,463.43** | **618,987,092.73** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **469,167,463.43** | **618,987,092.73** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **468,819,797.43** | **557,343,555.73** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **290,423,181.00** | **323,703,567.00** |
| 210101 | Үндсэн цалин | 261,808,220.00 | 290,431,630.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,808,000.00 | 4,529,000.00 |
| 210104 | Урамшуулал | 17,676,025.00 | 23,702,937.00 |
| 210105 | Гэрээтийн цалин | 5,130,936.00 | 5,040,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **36,218,163.00** | **41,061,677.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,191,256.00 | 30,301,026.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,971,071.00 | 2,128,982.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,207,538.00 | 2,362,122.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 662,423.00 | 695,045.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,185,875.00 | 5,574,502.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **29,910,483.00** | **32,715,539.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,927,927.00 | 1,716,268.00 |
| 210302 | Түлш, халаалт | 27,937,436.00 | 30,954,151.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 45,120.00 | 45,120.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **33,055,274.00** | **31,916,670.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,376,570.00 | 3,824,950.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,562,630.00 | 23,970,920.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 626,400.00 | 1,547,800.00 |
| 210405 | Хог хаягдал устгах ,цэвэрлэх | 692,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,232,300.00 | 2,573,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 9,565,374.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | **42,173,635.00** | **85,440,304.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 34,049,185.00 | 76,893,803.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,124,450.00 | 8,546,501.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,240,500.00** | **3,579,750.00** |
| **210601** | Багаж хэрэгсэл | | **309,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,240,500.00 | 3,270,750.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **238,000.00** | **396,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 238,000.00 | 396,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **921,050.00** | **1,492,300.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 148,200.00 | |
| 210802 | Аудит,баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 120,000.00 | 963,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 91,950.00 | 110,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 30,000.00 | 37,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 55,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 444,700.00 | 231,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 31,200.00 | 106,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **33,639,511.43** | **37,037,748.73** |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,237,000.00 | 40,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 32,402,511.43 | 36,997,748.73 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **347,666.00** | **61,643,537.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | | |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | **58,700,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 58,700,000.00 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 347,666.00 | 2,943,537.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **-28,556,017.43** | **92,819,892.50** |
| | **Үйл ажиллагааны бус зардлын дүн** | **17,417.32** | |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-28,573,434.75** | **92,819,892.50** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **418,518,450.00** | **568,806,580.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **418,518,450.00** | **568,806,580.00** |
| **131007** | **Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт** | **341,523,100.00** | **400,252,500.00** |
| | | | |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **18,937,900.00** | **105,873,300.00** |
| **131101** | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж | | **2,000,000.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 18,937,900.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 103,873,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 30,075,300.00 | 37,507,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 30,075,300.00 | 37,507,000.00 |
| | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 27,982,150.00 | 25,173,780.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 27,982,150.00 | 25,173,780.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **418,518,450.00** | **566,164,776.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **418,518,450.00** | **566,164,776.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **418,170,784.00** | **532,821,239.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **282,895,865.00** | **323,482,547.00** |
| 210101 | Үндсэн цалин | 253,376,467.00 | 290,210,610.00 |
| 210102 | Нэмэгдэл | | |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,808,000.00 | 4,529,000.00 |
| 210104 | Урамшуулал | 18,679,707.00 | 23,702,937.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,031,691.00 | 5,040,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **43,818,233.00** | **42,133,116.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,529,033.00 | 30,227,103.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,822,300.00 | 3,128,842.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,084,940.00 | 2,497,336.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 737,360.00 | 568,413.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,644,600.00 | 5,711,422.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **29,034,966.00** | **33,063,463.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,622,304.00 | 2,292,192.00 |
| 210302 | Түлш, халаалт | 27,367,542.00 | 30,726,151.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 45,120.00 | 45,120.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **23,708,170.00** | **50,327,090.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,250,000.00 | 2,645,070.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,404,870.00 | 24,333,820.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 926,400.00 | 1,547,800.00 |
| 210405 | Хог хаягдал | 847,910.00 | 231,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,278,990.00 | 21,569,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **30,460,500.00** | **70,208,523.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 22,460,500.00 | 58,582,038.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,600,000.00 | 9,129,485.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,400,000.00 | 2,497,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **5,206,000.00** | **8,300,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,795,000.00 | 4,500,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 375,000.00 | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,036,000.00 | 3,300,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **238,000.00** | **396,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 238,000.00 | 396,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **921,050.00** | **1,417,300.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 148,200.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 120,000.00 | 738,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 91,950.00 | 110,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 30,000.00 | 37,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 55,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл ,технологийн үйлчилгээ | 444,700.00 | 456,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 31,200.00 | 31,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,888,000.00** | **3,493,200.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,888,000.00 | 3,493,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **347,666.00** | **33,343,537.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | | |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | **30,400,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 30,400,000.00 |
| | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт,шилжүүлэг | 347,666.00 | 2,943,537.00 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 347,666.00 | 2,943,537.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | | **2,641,804.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | | |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | | |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | | **2,641,804.00** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 2,641,804.00 |

**2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **186,728,771.31** | **189,319,145.00** | **352,362,596.06** | **728410512.37** |
| 2 | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | | | | |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **186,728,771.31** | **189,319,145.00** | **352,362,596.06** | **728410512.37** |
| 4 | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | | | | |
| 5 | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | | | | |
| 6 | **Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз** | | | | |
| 7 | **Өмчид гарсан өөрчлөлт** | | | | |
| 8 | **Зарласан ногдол ашиг** | | | | |
| 9 | **Тайлант үеийн үр дүн** | | | **-28573434.75** | **-28573434.75** |
| 10 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **186,728,771.31** | **189,319,145.00** | **323,789,161.31** | **699,837,077.62** |
| 11 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **186,728,771.31** | **189,319,145.00** | **323,789,161.31** | **699,837,077.62** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **186,728,771.31** | **189,319,145.00** | **323,789,161.31** | **699,837,077.62** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | | | |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | | | | |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | |
| 18 | Зарласан ногдол ашиг | | | | |
| 19 | Тайлант үеийн үр дүн | | | 92,819,892.50 | 92,819,892.50 |
| 20 | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **186,728,771.31** | **189,319,145.00** | **416,609,053.81** | **792,656,970.12** |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **468,860,800.00** | **458,567,939.00** | 10,292,861.00 | 97.8 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **468,860,800.00** | **458,567,939.00** | 10,292,861.00 | 97.8 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **468,860,800.00** | **458,567,939.00** | 10,292,861.00 | 97.8 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **311,169,700.00** | **306,771,248.00** | 4,398,452.00 | 98.6 |
| 210101 | Үндсэн цалин | 272,261,200.00 | 273,499,311.00 | -1,238,111.00 | 100.5 |
| 210102 | Нэмэгдэл | 5,808,000.00 | 4,529,000.00 | 1,279,000.00 | 78.0 |
| 210104 | Урамшуулал | 28,060,500.00 | 23,702,937.00 | 4,357,563.00 | 84.5 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,040,000.00 | 5,040,000.00 | 0.00 | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **42,007,900.00** | **40,164,088.00** | 1,843,812.00 | 95.6 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,561,100.00 | 28,258,075.00 | 1,303,025.00 | 95.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,111,700.00 | 3,128,842.00 | -17,142.00 | 100.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,489,300.00 | 2,497,336.00 | -8,036.00 | 100.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 622,400.00 | 568,413.00 | 53,987.00 | 91.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,223,400.00 | 5,711,422.00 | 511,978.00 | 91.8 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **36,007,000.00** | **33,063,463.00** | 2,943,537.00 | 91.8 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,300,000.00 | 2,292,192.00 | 7,808.00 | 99.7 |
| 210302 | Түлш, халаалт | 33,387,000.00 | 30,726,151.00 | 2,660,849.00 | 92.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 320,000.00 | 45,120.00 | 274,880.00 | 14.1 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **29,896,000.00** | **29,885,640.00** | 10,360.00 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,650,000.00 | 1,635,470.00 | 14,530.00 | 99.1 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,286,000.00 | 23,161,970.00 | -1,875,970.00 | 108.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,860,000.00 | 1,547,800.00 | 312,200.00 | 83.2 |
| 210404 | Ном хэвлэл | 100,000.00 | 0 | 100,000.00 | 0.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах,хортон мэрэгчдийн устгал,ариутгал | 1,800,000.00 | 231,000.00 | 1,569,000.00 | 12.8 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,200,000.00 | 3,309,400.00 | -109,400.00 | 103.4 |
| **2105** | **Нормативт зардал** | **36,880,000.00** | **36,877,000.00** | 3,000.00 | 100.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 26,180,000.00 | 26,180,000.00 | 0.00 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 8,200,000.00 | 8,200,000.00 | 0.00 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,500,000.00 | 2,497,000.00 | 3,000.00 | 99.9 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,500,000.00** | **6,500,000.00** | 0.00 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,500,000.00 | 4,500,000.00 | 0.00 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 500,000.00 | 500,000.00 | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 1,500,000.00 | 1,500,000.00 | 0.00 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,150,000.00** | **396,000.00** | 754,000.00 | 34.4 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,150,000.00 | 396,000.00 | 754,000.00 | 34.4 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,754,900.00** | **1,417,300.00** | 337,600.00 | 80.8 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 300,000.00 | 0 | 300,000.00 | 0.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт,зэрэглэл тогтоох | 738,000.00 | 738,000.00 | 0.00 | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 110,600.00 | 110,600.00 | 0.00 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 55,100.00 | 37,500.00 | 17,600.00 | 68.1 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 55,000.00 | 44,000.00 | 11,000.00 | 80.0 |
| 210806 | Мэдээлэл,технологийн үйлчилгээ | 465,000.00 | 456,000.00 | 9,000.00 | 98.1 |
| 210807 | Газрын төлбөр | 31,200.00 | 31,200.00 | 0.00 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **3,495,300.00** | **3,493,200.00** | 2,100.00 | 99.9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | **3,495,300.00** | **3,493,200.00** | 2,100.00 | 99.9 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **468,860,800.00** | **462,933,280.00** | 5,927,520.00 | 98.7 |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **400,252,500.00** | **400,252,500.00** | 0.00 | 100.0 |
| 310002 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 400,252,500.00 | 400,252,500.00 | 0.00 | 100.0 |
| **32** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **37,507,000.00** | **37,507,000.00** | 0.00 | 100.0 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 37,507,000.00 | 37,507,000.00 | 0.00 | 100.0 |
| **33** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **31,101,300.00** | **25,173,780.00** | 5,927,520.00 | 80.9 |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 31,101,300.00 | 25,173,780.00 | 5,927,520.00 | 80.9 |
| **5** | **Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **1,421,804.00** | -1,421,804.00 | |
| | | | | | |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **104,653,300.00** | | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **104,653,300.00** | | |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **74,253,300.00** | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **20,441,450.00** | | |
| 210401 | Бичиг хэрэг | | 1,009,600.00 | | |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 1,171,850.00 | | |
| 210406 | Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс | | 18,260,000.00 | | |
| 2105 | Нормтивт зардал | | 33,331,523.00 | | |
| 210501 | Эм бэлдмэл,эмнэлгийн хэрэгсэл | | 32,402,523.00 | | |
| 210502 | Хоол хүнс | | 929,485.00 | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **1,800,000.00** | | |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | | | |
| 210604 | Урсгал засвар | | 1,800,000.00 | | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **30,400,000.00** | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | **30,400,000.00** | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 30,400,000.00 | | |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **105,873,300.00** | | |
| **31** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **105,873,300.00** | | |
| **131101** | **Төрийн болон орон нутгийн өмчит бус иргэдээс авсан хандив,тусламж** | | **2,000,000.00** | | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | | | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | | | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого<br><br>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ | | 103,873,300.00<br><br>1,220,000.00 | | |
| 10 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 1,220,000.00 | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Ховд сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Ховд сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2022 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 112 дугаар албан бичиг ирүүлсэн.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд сумын Эрүүл мэндийн төв нь эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулж үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад дотоод аудитын чиг үүрэг бүхий байгууллагуудаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд Увс аймгийн Ховд сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 469,167.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,691.7 мянган төгрөгөөр тооцсон, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 618,987.1 мянган төгрөгийн 1 хувиар буюу 6,189.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 4.951.9 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд Ховд сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Увс аймгийн Ховд сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 136,162.2 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оноос өөрчлөлт орсон авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 0 | 38,564.0 | 38,564.0 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 258,680.1 | 292,073.7 | 33,393.6 |
| Үндсэн хөрөнгө | 4,863,139.5 | 4,655,019.7 | -208,119.8 |
| **Нийт хөрөнгө** | 5,121,819.6 | 4,985,657.4 | -136,162.2 |
| Өр төлбөр | 311.1 | 0 | -311.1 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 5,121,508.5 | 4,985,657.4 | -135,851.1 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 5,121,819.6 | 4,985,657.4 | -136,162.2 |

Авлага дансны үлдэгдэл 38,564.0 мянган төгрөг болж 38,564.0 мянган төгрөгөөр өссөн нь Цалин, НДШ-ийн хэмнэлтийг татвар, нийгмийн даатгалд шилжүүлснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 292,073.7 мянган төгрөг болж 33,393.6 мянган төгрөгөөр өссөн нь Боловсролын яамнаас хөрөнгө оруулалтаар ирсэн хими, физикийн урвалж бодис, жижиг багаж хэрэгсэл, бага ангийн сургалтын хэрэглэгдэхүүн зэргийг тусгай зориулалтын материал, аж ахуйн материал, бусад хангамжийн материалын дансанд бүртгэгдсэнээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,655,019.7 мянган төгрөг болж 208,119.8 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдэл болон акталсан үндсэн хөрөнгөөс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 68,221.5 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 11,891.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 22,874.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 311.1 мянган төгрөгөөр буурсан нь НДШ-ийн өглөгийг барагдуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,985,657.4 мянган төгрөг болж 135,851.1 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 182,804.9 мянган төгрөгөөр буюу 4.9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан үндсэн үйл ажиллагааны орлого, үнэ төлбөргүй хүлээж авсан хөрөнгө, материал болон нэмэлт санхүүжилтийн дансны орлого байна. Энэ нь салбар яамнаас хөрөнгө оруулалт хийгдсэн, төсөл хөтөлбөр хэрэгжсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 185,276.7 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өсөхөд цалин, НДШ, түлш халаалт, цэвэр бохир ус, эд хогшил, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлсэн хоол, хичээл практик, урсгал шилжүүлэг зэрэг зардал голчлон нөлөөлжээ. Энэ нь 2019, 2020 онд хичээл сургалтын үйл ажиллагаа ковид-19 цар тахалтай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,135,485.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,135,485.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 307,540.6 мянган төгрөгөөр бууруулж 3,827,944.6 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 121,936.2 мянган төгрөгийн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, тэтгэвэр гарахад нэг удаа олгох тэтгэмжийн зардлыг аймгийн Боловсрол соёлын газарт авч үлдсэн болон цалин, НДШ, бусад зардалд 185,604.4 мянган төгрөг төсөвлөснөөс дутуу батлагдаж иржээ.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,827.944.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 3,286,812.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 516,223.7 мянган төгрөгийн орон нутгийн төсвөөс, 24,908.4 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,286,812.5 мянга, орон нутгийн төсвөөс 515,363.8 мянган төгрөг авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 24,908.4 мянган төгрөг оруулж, нийт 3,827,084.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 3,781,281.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үндсэн үйл ажиллагааны данснаас 45,803.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,781,281.1 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 10,597.5 мянга, ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 5,000.0 мянга, Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 1,370.9 мянга,Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 21,359.4 мянга, нийт 38,327.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бичиг хэрэг зардалд 1,729.4 мянга, тээвэр шатахуун зардалд 150.7 мянга, хог хаягдал, хортон мэрэгчдийн устгал зардалд 630.0 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс зардалд 6,156.3 мянга, багаж техник хэрэгсэл зардалд 21,894.3 мянга, тавилга, эд хогшлын зардалд 761.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 1,650.0 мянга, мэдээлэл технологийн зардалд 1,105.0 мянга, хичээл үйлдвэрлэл дадлага хийх зардалд 2,208.4 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 2,042.5 мянга, нийт 38,327.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас 0.042 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Ховд сумын Эрүүл мэндийн төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс 114 мэдээллийг хугацаандаа 36 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна. Мэдээлэх хугацаа болоогүй 1 мэдээлэл байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний орлогын авлага 42,975.2 мянган төгрөг байна. Тухайн авлагын дагуу 2022 оны 1 дүгээр сард санхүүжилтийг олгосон байна. Дараагийн аудитаар тухайн авлагын зарцуулалтыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 28,047.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 27570.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 477.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

### 4.1 Залруулсан алдаа

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3 дахь заалтад "Бүх өр төлбөр" гэж заасныг зөрчин 27,570.3 мянган төгрөгийн өглөгийг данс бүртгэлд тусгаагүй байсныг залруулга хийлгэсэн.

### 4.2 Төлбөрийн акт

1. Засгийн газрын 2019 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл"-ийн 5-д Эх баригч их эмч ТҮЭМ-5 шатлалаар цалинжуулахаар тогтоосныг зөрчиж эх баригч эмч Я.Цэгмэдийг ТҮЭМ-5-ийн 1 шатлалаар 731369 төгрөгөөр тогтоохоор байсныг ТҮЭМ-4-ийн 1 дүгээр шатлалаар 703623 төгрөгөөр тогтоож нийт 477.3 мянган төгрөгийг дутуу олгосон байсанд төлбөрийн акт тогтоосон.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Ховд сумын Эрүүл мэндийн төвийн | 2 | 28,047.6 | 1 | 27,570.3 | 1 | 477.3 | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР /Т.НАМЖИЛ/

2022 оны 02 сарын 24-ний өдөр